

Mongolian A: literature – Standard level – Paper 1
Mongol A : littérature – Niveau moyen – Épreuve 1
Mongol A: literatura – Nivel medio – Prueba 1

Wednesday 4 May 2016 (afternoon)
Mercredi 4 mai 2016 (après-midi)
Miércoles 4 de mayo de 2016 (tarde)

1 hour 30 minutes / 1 heure 30 minutes / 1 hora 30 minutos

Instructions to candidates

- Do not open this examination paper until instructed to do so.
- Write a guided literary analysis on one passage only. In your answer you must address both of the guiding questions provided.
- The maximum mark for this examination paper is **[20 marks]**.

Instructions destinées aux candidats

- N'ouvrez pas cette épreuve avant d'y être autorisé(e).
- Rédigez une analyse littéraire dirigée d'un seul des passages. Les deux questions d'orientation fournies doivent être traitées dans votre réponse.
- Le nombre maximum de points pour cette épreuve d'examen est de **[20 points]**.

Instrucciones para los alumnos

- No abra esta prueba hasta que se lo autoricen.
- Escriba un análisis literario guiado sobre un solo pasaje. Debe abordar las dos preguntas de orientación en su respuesta.
- La puntuación máxima para esta prueba de examen es **[20 puntos]**.

Доорх хоёр зохиолоос зөвхөн **нэгийг** нь сонгож, хөтөч хоёр асуултын дагуу уран зохиолын талаас задлан тайлбарлаж бич.

1.

Гэнэт морь нь үүрсэн янцгааж газар цавчлахад хүү сэрвэл морин төвөргөөн сонстож, удалгүй хэдэн морьтон гарч ирэхэд дэргэдээс нь зугтаад гүйцээгүй юм, ийм зайтай холоос яаж гүйцэх вэ? Миний бие ч, морь ч жаахан амарсан гээд яаралгүй мордоод ухасхийтэл морь нь чөдөртэй юм шиг таталдаад явж чадсангүй. Би юунд бууж унтав даа, ингээд

5 баригддаг байжээ хэмээн бодоод эгэн хартал нарийн шарга морьтой хүн хол түрүүлэн ирж явжээ. Гэтэл эмэгтэй хүний дуу гарч “Эр хүн байж надаас дор, юм санахгүй байна уу? Зүүж яваа хэтнийхээ цахиурыг тоолж, ерөөсгөл болгооч, хадам аавын захисныг санаж яваач” гэхээр нь цахиурыг тоолсонд дөрөв байсан тул нэгийг нь авч хаятал морь нь урьдын адил хурдалж дүүгүүрийн чулуу адил дүүлж гарлаа (Үүнээс хойш хэтний цахиурыг

10 сондгой тоотой хийх болсон гэдэг).

Шарга морьтой бүсгүй нэхэн ойртож ирээд “Одоо босоо хошгирсон тарвагатай газар амраарай. Би чамайг гүйцэхгүй хүн болоод хоцоръё. Чи минь болгоомжтой, сайн яваарай. Хожим баяртай уулзахын ерөөл тавья.” гэж хоолойгоо зангируулан хэлээд дуу нь улам бүдгэрсээр хоцорчээ.

15 Хүү хэдэн өдөр шөнө зогсолгүй давхисаар үнэхээр ч ядарч нойр нь хүрэх авч тарвага нь хэвтээ хошгирсон газар буусангүй, огоот тэвчин явсаар тарвага нь босоо хошгирсон нутагт ирж унтаж, морио ч амрааж, тэгээд цааш одон, өсөж төрсөн халхын нутагтаа ирж, аав ээжийгээ сурагласаар уулзжээ.

Аав ээж нь өтөлсөн боловч хүүгээ үзэж, сэтгэл санаа нь сэргэж, урам зориг ч орж, аав хүү хоёр өөлдийн Шар баатартай дайтахаар цэрэг зэвсэг, агт морьд хуралдуулан бэлтгэж атал Шар баатар хааныхан Аралдай тайжийн хүүг нэхэж айсуу гэх мэдээ иржээ. Шар баатар хаан ямагт цэргээсээ гурав хоногийн газар түрүүлж явах агаад нэг унтахаараа гурав хоног унтдаг гэдгийг Аралдай хүү хоёр тагнан мэдэж, урдаас нь Аралдайн хүү угтан очиход Шар баатар гурав хоногийн газар түрүүлэн ирж, буу зэвсгээ дэргэдээ тавиад,

25 алтан бариултай сэлмээ нуруун дороо хийгээд унтаж байхад нь хүү ирж, зүрх рүү нь буудтал Шар баатар:

– Юун буун дуу гарч, дарь хүхэр үнэртэв? гэсээр ер тоосон шинжгүй өндийж ирэхэд өрц рүү нь хэд дахин жадалж газартай хаджээ. Гэтэл нэг гараараа нуруун доорхи сэлмээ авч хүүгийн толгойг цавчих гэснээ азнаж, “За, чамайг ингэж сэм ирж гэнэдүүлнэ гэж даанч санасангүй. Буудуулж бас жадлууллаа. Түүнээс биш чамайг дийлэх байсан юм. Одоо ч гэсэн чи миний сэлэмнээс гарч чадахгүй” гээд сэлмээрээ хүүгийн хүзүүн дээр дарахад хүү хөдөлж ч чадахгүй байлаа.

30

– За, хүү минь! Хоёр баатар нэгийгээ ялдгаас биш, нэг дор үхэж байсан түүх үгүй юм. Иймээс чи урьтаж, би нэгэнт сэхэл авахгүй болсон болохоор үхье. Чамайг би одоо нэгэнт алж чадах авч би цэргээ иртэл амьд байж чадахгүй болжээ. Чи миний цэргүүд болон албат иргэдийг хүйс тэмтэрч болохгүй шүү. Одоо жадаа сугал даа гэв. Жадыг үтэр сугалахуйд Шар баатар хаан аминаас хагацжээ. Аралдайн хүү цэргүүдийнхээ хамт өөлдийн Шар баатар хааны цэргийн өөдөөс очиж “Танай хаан алагдсан. Одоо та нар бууж өг!” хэмээн баатрын зэвсгийг үзүүлэхэд өөлдийн цэрэг нэгэнт хаангүй болсон тул

35 бууж өгөв. Хүү Шар баатрын нутагт очин сэтгэлт бүсгүй Сэржмядаг болон халхаас олзонд очсон албатуудаа авч эгэн иржээ. Харин сайхан сэтгэлээр өсгөсөн эмгэн өвгөн хоёр нь харамсалтайгаар нэгэнт хороогдсон байлаа.

40

- Ингээд Аралдайн хүүгийн нэр алдар тодорч улмаар олон түмэн баатар цол өргөмжилж, халхыг захируулжээ. Аралдай тайж хүүдээ Хатан нэр өгсөн байж.
- 45 Бойжуулсан эцэг эх нь Бүүвэй хэмээн нэрлэж, олон түмэн Баатар болгосон учир Хатан бүүвэй баатар хэмээн нэрийдэх болжээ.

Зохиогч нь тодорхойгүй, *Хатан бүүвэй баатар* (1959)

- (а) Зохиолын энэ хэсэгт Хатан бүүвэй баатрын ялалтаар ямар утга санааг дүрсэлсэн байна вэ?
- (б) Зохиолын энэ хэсэгт дүрүүдийн хүч чадлыг хэрхэн дүрсэлсэн байна вэ?

2.

[...]
Эцгийн сайхан өвөр шиг
нөмөртэй байдаг ууланд нь
Эрхэлж явах насандаа
цэцгийг нь түүсэн газар
5 Эхийн сайхан сэтгэл шиг
уужим саруул хөндийд нь
Өдий болж өстлөө
миний гэсэн шороо!
Боролдой бяцхан гартаа
10 харандааг анх барьж
Булбарай хөөрхөн биеэрээ
ширээ түшиж суухаас
Бодол оюун хоёрыг минь
улам ихээр эзэлж
15 Бодьтой сайхан чанар нь
миний зүрхэнд шингэсэн
Хэзээний миний нутаг бол
Хэнтий, Хангайн нуруу
Хэрлэн, Онон, Туулын
20 ариун уст мөрөн
Хэдий дээрээс алдартай
малчин монгол олны
Хэтээс сайхан хөгжлийн
өлгий болсон нутаг
25 Цэлмэг залуу насныхаа
гал дөлөөр бадарч
Сэтгэл зүрх хоёртоо
шатаж явах үедээ
Чин сайхан амрагтаа
30 хэлж үзээгүй мөртөө
Чиний төлөө үхье гэж
эх орондоо хэлдэг
Угаас төрсөн нутаг минь
энэ монголын орон
35 Урьд хожид хэзээ ч бол
угаасан сайхан ус
Уур цагаан гэртээ
түлсэн халуун гал
Ухаан орсон цагаас
40 миний гэсэн шороо!
[...]

Ц.Цэдэнжав, *Миний нутаг* (1947)

- (а) Хүүхэд наснаас эхлэн насанд хүрсэн үеэр дамжуулан ямар утга санааг илэрхийлсэн байна вэ?
- (б) Зохиолын агуулгыг хэл найруулга болон бүтцийн ямар онцлогоор дүрсэлсэн байна вэ?